

## КАНАД, АМЕРИКИЙН ХАРИЛЦАА, ЧИГ ХАНДЛАГА

*Д.Өэлүн-Үжин\**

Канад улс, хөрш Америктай тогтоосон харилцаа, хамтын ажиллагаа Английн колонийн үеэс буюу 200 орчим жилийн өмнөөс эхэлсэн түүхтэй. Энэ хоёр орны харилцааг олон улсын харилцааны шинэхэн түүхэнд итгэлцэлд тулгуурласан, иж бүрэн хамтын ажиллагааны сонгодог жишээ гэж үздэг. Хэдийгээр хөрш нь хүн ам, үндэсний баялгаар Канадаас 10 дахин их хэдий ч хоёр орны хоорондын асар их хэмжээний худалдаа хийгээд цагаачлал нь нягт харилцаа хамтын ажиллагааны үндэс суурь болдог юм.

Өнөөдөр ч гэсэн Канад, Америк хоёр дэлхийн хамгийн том худалдааны түнш, дэлхийд хамгийн урт цэрэггүй дундын хилтэй, илүү өвөрмөц, ойр дөт харилцаатай хөршүүд юм. Тийм ч учраас олон улсын харилцааны алив асуудалд Америктай нэг хүч болж оролцдог.

Хоёр орны харилцаанд учирч буй өнөөгийн тулгамдсан асуудал гэвэл худалдааны байнгын алдагдал, байгаль орчны асуудал, дундын хил орчмын цагаачлал, хүмүүсийн шилжилт хөдөлгөөн юм.

Энэхүү бэсрэг өгүүлэлд тэр бүхнийг авч үзэх боломжгүй тул зөвхөн хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааны асуудлыг товч хөндөж үзэхийг хичээв.

1987 онд Канад, Америк хоёр улсын хооронд байгуулсан Чөлөөт худалдааны Хэлэлцээрээр хоёр улсын бараа бүтээгдэхүүнийг хоёр улсын хилээр гаалийн татваргүй гаргах болсон. Өнөөг хүртэл энэ хэлэлцээр мөрдөгдөж байгаа хэдий ч худалдааны алдагдал, маргаан хоёр улсын хооронд байнга шахуу гарч хоёр улсын хооронд хийж буй худалдааны хэмжээ зарим үед буурах хандлага ажиглагддаг. Энэ нь юуны өмнө Америкийн тал Канадаас импортлож буй модны асуудал юм. Канадын тал Америкт экспортлож буй төрөл бүрийн мод, гуалин зэргийг бараа бүтээгдэхүүн биш гэж үздэг учир гаалийн татвар тогтоохыг хүсдэг. Гэтэл Америкийн тал Чөлөөт Худалдааны Хэлэлцээрээ бариад хүлээж авдаггүй. Энэ маргаан Дэлхийн Худалдааны Байгууллага, НАФТА-д жил бүр яригдаж байдаг ч өнөөг хүртэл нэг мөр шийдэгдээгүй л байна. Шүүмжлэл маргааны нэг гол эх үүсвэр нь Америкийн хэвлэл, телевиз, кино ямар ч хаалт саадгүй Канад руу урсаж байгаа нь Канадын соёлын өвд нөлөөлж байгаа явдал гэж үздэг. Канадын тал хичнээн асуудал болгосон ч канадчуудад өдөр тутмын эрэлт хэрэгцээ хэвээр л байна. Түүнчлэн канадчууд Америкийн үхрийн махны гол хэрэглэгч болж ирсэн хэдий ч 2003 онд Америкт шүлхий гарч үхрийн мах авахгүй байгаа нь мөн л маргаан үүсгэж

\* Д.Өэлүн-Үжин - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

байна. Хоёр орны худалдааны энэ мэт маргааны талаар Канадын ерөнхий сайд Степен Харперын 2006 оны гуравдугаар сарын сүүлчээр АНУ-д хийсэн айлчлалын үеэр Ерөнхийлөгч Буштай хийсэн уулзалтын үеэр нааштай шийдэлд хүрсэн байна.

Канадаас Америкт суугаа Элчингийн судалгаагаар, Канадын Америктай хийх худалдааны дэмжлэг нь зөвхөн 2001 оны байдлаар Америкт 5.2 сая ажлын байр бий болгосон байна.

Канад, АНУ хоёр улс худалдаа, эдийн засгийн харилцааны арвин их түүхтэй боловч уг гэрээ байгуулагдсанаас хойш худалдаа, хөрөнгө оруулалтын хэмжээ эрс нэмэгдсэн бөгөөд 1990-ээд оноос өмнө Канад, АНУ-ын хөрөнгө оруулалтын 8 орчим хувийг хангадаг байсан бол 1999 оны сүүл гэхэд АНУ-д оруулсан Канадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 90.4 тэрбум доллар болов. Эдгээр хөрөнгө оруулалтын ихэнх хувь нь үл хөдлөх хөрөнгө, газрын тос, даатгал, бөөний худалдаа зэрэгт ордог байна. Харин АНУ-ын шууд хөрөнгө оруулалт 116.7 тэрбум долларт хүрч өссөн байна.

Худалдаа, хөрөнгө оруулалтаараа АНУ, Канад улстай өдөрт 1.4 тэрбум долларын худалдаа хийдэг чухал түншийн хувьд 1999 онд гэхэд хоёр орны худалдаа нь Латин Америкийн бүх орнуудтай хийсэн худалдаанаас давж гарснаас гадна, Канад руу гаргадаг Америкийн экспортын хэмжээ Европын холбооны бүх гишүүн орнуудад гаргагдаас ч мөн давж байна.

Канад хүнсний ногоо, жимс, малын гаралтай бүтээгдэхүүн экспортод гаргагдаараа АНУ-ын Хөдөө аж ахуйн үйлдвэрийн бүтээгдэхүүний гуравны хоёр орчим хувийг эзэлдэгээс гадна АНУ-ын газрын тосны импортын 16 орчим хувь, байгалийн хийн 14 орчим хувийг нийлүүлдэг байна.

Харин АНУ нь Канадын уул уурхай, газрын тос, хайлуулах үйлдвэр, тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмж, үйлдвэрлэл, санхүүгийн салбарт ихэвчлэн хөрөнгө оруулдаг бөгөөд хилийн чанад дахь хөрөнгө оруулалтынхаа 65 хувийг Канадад оруулдаг бол Канад нь нийт экспортын 80 хувийг АНУ-д гаргадаг аж. Энэ бүхнээс үзэхэд Канад, Америкийн худалдааны харилцаа цаашид ч улам бүр тэлэн өргөжих чиг хандлагатай байна гэж үзэж болох юм.

Дэлхийн өндөр хөгжилтэй Канад улс АНУ-тай хамтран бүс нутгийн хамтын ажиллагаанд ихээхэн анхаарал хандуулж ач холбогдол өгдөгийн нэгэн илрэл нь 1992 оны арванхоёрдугаар сард Хойд Америкийн ассиосаци буюу НАФТА байгуулагдахад ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн явдал юм..

Үүний үр дүнд НАФТА-гийн Чөлөөт худалдааны ассиосаци 1994 оны нэгдүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болов. Улмаар АНУ, Канад, Мексик гурван улс 8.5 триллион долларын бүтээгдэхүүнийг

хамтран үйлдвэрлэж, борлуулалт үйлчилгээг нь хамтран явуулах гэрээ байгуулсан байна.

НАФТА-г АНУ, Канад, Мексик дараах хэд хэдэн зорилгын үндсэн дээр байгуулжээ. Үүнд:

- Гурван улсын хоорондын худалдааг харилцан тохиролцсон хугацаанд элдэв татвараас чөлөөлөх

- Худалдаа үйлчилгээ явуулахад учрах саад бэрхшээлийг бууруулах

- Гурван улсын хоорондох гадаадын хөрөнгө оруулалтад тавигдах хязгаарлалтыг багасгах

- Оюуны өмчийн эрхийн хангалтыг баталгаажуулах

Уг хэлэлцээрийн хэрэгжилтийн явцад НАФТА-гийн гишүүн аль улсаас бараа бүтээгдэхүүн гаралтай болохоос хамааран татварын хувь хэмжээ харилцан адилгүй байхаар заажээ.

НАФТА байгуулагдсанаас хойш Канадын эдийн засаг жил бүр дунджаар 3.8 хувиар өсч байгаагаас Их Наймын орнууд дотор тэргүүлэх байр суурьтай байна.

НАФТА-ийн түнш орнуудын хоорондын нийт худалдаа жил бүр тууштай өссөөр ирсэн агаад 2000 он гэхэд АНУ-Канадын худалдаа 588.7 тэрбум доллар, Мексик-Канадын худалдаа 1994 оноос хойш хоёр дахин нэмэгдэж 141 тэрбум долларт хүрсэн аж.

НАФТА-гийн зах зээлд нэвтрэх боломж, худалдаа хөрөнгө оруулалтын оновчтой бодлогын ачаар Канад руу гадаад дотоодын хөрөнгө оруулагчид ихээр татагсанаар 2000 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт 292 тэрбум доллар болсны 186 тэрбум ам.долларыг АНУ оруулжээ.

2006 оны байдлаар НАФТА-гийн гишүүн гурван орны гадаад худалдааны эргэлт нийтдээ 958 тэрбум долларт хүрсэн тооцоо байна.

Ийнхүү байгуулагдаад 16 жилийн нүүрийг үзэж буй хүчтэй, орчин үеийн, уян хатан бодлого баримтлагч НАФТА-ийн гишүүн орнууд асар хурдацтайгаар хөгжин улам бүр даяарчлагдаж буй дэлхийн зах зээлтэй өрсөлдөх чадвар нь улам нэмэгдсээр байна.

### **Ашигласан материал**

1. Ц.Баатар. “Глобалчлалын эриний Америкийн эдийн засаг”. 2004 он, УБ
2. Д.Авирмэд. “Олон улсын эдийн засгийн харилцаа”. 2007 он, УБ
3. АНУ-ын эдийн засгийн тойм
4. [www.canada.com](http://www.canada.com)
5. [www.ustr.gov](http://www.ustr.gov)
6. [www.NAFTA.com](http://www.NAFTA.com)
7. [www.norad.mill](http://www.norad.mill)